

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өндөрхангай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2022/156/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Улаангом хот
2022 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,
Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь
Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn
Аудитын менежер: М.Бат-Амгалан
Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn
Аудитор: Т.Амармэнд
Утас: 70453721, Цахим хаяг: Amarmendt@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
3. Аудитын тайлан	12
3.1 Ерөнхий зүйл	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал.....	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	15
3.8 Аудитын гол асуудал.....	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт.....	16
4.1 Залруулсан алдаа	16
5.Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	16

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

2022.02.25 № УВА - 2022/56/НА-СН-ТМБ
танай _____-ны № _____-т

ӨНДӨРХАНГАЙ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Я.ГАНБАЯР ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу аймгийн Өндөрхангай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өндөрхангай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.



Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

0200200215

2.1. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	68,217,953.38	92,449,973.49
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	00.00
33	АВЛАГА	14,092,988.00	25,609,988.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	211,988.00	211,988.00
335	Бусад авлага	13,881,000.00	25,398,000.00
3351	Байгууллагаас авах авлага	13,881,000.00	25,398,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	54,124,965.38	66,839,985.49
351	Түүхий эд материал	3,660,362.38	9,444,817.13
35110	Тусгай зориулалттай материал	3,144,862.38	9,090,417.13
35130	Эм боох материал	515,500.00	354,400.00
354	Хангамжийн материал	50,464,603.00	57,395,168.36
35410	Бичиг хэргийн материал	8,475,666.00	7,494,122.00
35420	Аж ахуйн материал	28,628,096.00	24,799,727.15
35430	Сэлбэг хэрэгсэл	898,000.00	628,000.00
35450	Барилгын засварын материал	490,000.00	2,299,000.00
35460	Хүнсний материал	11,022,841.00	10,761,232.00
35470	Бусад хангамжийн материал	950,000.00	11,413,087.21
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,763,457,067.00	1,693,029,265.04
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,763,457,067.00	1,693,029,265.04
392	Биет хөрөнгө	1,691,592,466.95	1,621,384,664.95
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,653,299,986.23	1,676,924,746.23
39202	Хуримтлагдсан элэгдэл	-92,391,727.06	-160,453,785.70
39203	Авто-тээврийн хэрэгсэл	21,500,000.00	21,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-21,500,000.00	-21,500,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	266,141,785.40	174,545,770.09
39206	Хуримтлагдсан элэгдэл	-216,033,220.97	-137,212,375.16
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	148,046,085.80	112,839,420.67
39208	Хуримтлагдсан элэгдэл	-89,963,916.34	-67,752,585.07
39217	Ном	22,493,473.89	22,493,473.89
393	Биет бус хөрөнгө	71,864,600.05	71,644,600.09
39301	Програм хангамж	3,700,000.00	2,650,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-3,404,999.95	-2,574,999.91
39303	Бусад биет бус хөрөнгө	71,569,600.00	71,569,600.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,831,675,020.38	1,785,479,238.53
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,171,224.77	109,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,171,224.77	109,000.00
413	Өглөг	1,171,224.77	109,000.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,165,315.77	00.00
4136	Бусад өглөг	5,909.00	109,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	5,909.00	109,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,830,503,795.61	1,785,370,238.53
51	Засгийн газрын хувь оролцоо	1,830,503,795.61	1,785,370,238.53
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,223,869,576.73	1,223,869,576.73
51101	Өмч: - төрийн	1,223,869,576.73	1,223,869,576.73
512	Хуримтлагдсан үр дүн	335,563,809.81	290,587,095.73
51210	Өмнөх үеийн үр дүн	335,563,809.81	335,720,652.81
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-45,133,557.08
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	271,070,409.07	270,913,566.07
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,831,675,020.38	1,785,479,238.53

2.2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,195,566,254.38	1,156,909,595.11
11	ТАТВАРЫН ОРЛОГО	00.00	00.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,195,566,254.38	1,148,132,053.11
120	Нийтлэг татварын бус орлого	47,205,054.38	51,742,653.11
122	Тусламжийн орлого	129,252,300.00	145,154,900.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	1,019,108,900.00	951,234,500.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	1,019,108,900.00	951,234,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	00.00	8,777,542.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	8,777,542.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	8,777,542.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,224,171,957.70	1,191,870,999.67
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,224,171,957.70	1,191,870,999.67
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,166,691,680.97	1,122,907,837.57
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	803,258,019.77	762,878,421.26
210101	Үндсэн цалин	522,790,821.77	508,023,496.33
210102	Нэмэгдэл	200,721,534.00	199,253,950.40
210104	Урамшуулал	69,666,506.00	44,804,220.45
210105	Гэрээт ажлын хөлс	10,079,158.00	10,796,754.08
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	100,410,399.00	96,658,073.47
210201	Тэтгэврийн даатгал	67,709,114.16	68,892,815.09
210202	Тэтгэмжийн даатгал	7,811,817.87	7,112,983.44
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,462,734.85	5,862,749.15
210204	Ажилгүйдлийн даатгал	1,601,980.66	1,437,801.67
210205	Эрүүл мэндийн даатгал	16,824,751.46	13,351,724.12
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	126,645,985.73	115,944,277.40
210301	Гэрэл, цахилгаан	7,793,684.00	4,671,471.20
210302	Түлш, халаалт	118,702,301.73	110,972,806.20
210303	Цэвэр, бохир ус	150,000.00	300,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,328,964.00	15,870,446.00
210401	Бичиг хэрэг	718,000.00	3,747,416.00
210402	Тээвэр, шатахуун	4,549,500.00	4,608,890.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	582,000.00	571,800.00
210404	Ном, хэвлэл	232,000.00	39,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,635,450.00	63,540.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,612,014.00	3,455,300.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	00.00	00.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	3,384,500.00
2105	Нормативт зардал	17,640,005.00	23,244,690.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	179,700.00	2,036,060.00
210502	Хоол, хүнс	17,460,305.00	21,208,630.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,640,040.00	711,000.00

Өндөрхангай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210604	Урсгал засвар	1,640,040.00	711,000.00
2107	Томилолт, зочны зардал	311,000.00	750,000.00
210702	Дотоод албан томилолт	311,000.00	750,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	664,000.00	1,657,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	224,000.00	403,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	79,500.00	79,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	37,500.00	37,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	323,000.00	1,137,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	106,793,267.47	105,193,229.44
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,929,600.00	5,887,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	103,863,667.47	99,305,629.44
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	57,480,276.73	68,963,162.10
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,833,214.00	46,343,892.60
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	15,438,714.00	44,889,392.60
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,394,500.00	1,454,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	00.00
213304	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	1,483,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	115,514.27	22,619,269.50
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	115,514.27	10,233,009.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	40,531,548.46	10,903,260.50
213504	Хөрөнгийн	40,531,548.46	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-28,605,703.32	-34,961,404.56
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	10,172,152.52
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	1,973,755.22
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	8,198,397.30
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-10,172,152.52
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-28,605,703.32	-45,133,557.08

2.3. АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,148,361,200.00	1,106,649,942.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	00.00	00.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,148,361,200.00	1,096,389,400.00
122	Тусламжийн орлого	129,252,300.00	145,154,900.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	1,019,108,900.00	951,234,500.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	1,019,108,900.00	951,234,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	00.00	10,260,542.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	10,260,542.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	10,260,542.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,143,492,050.00	1,106,649,942.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,143,492,050.00	1,106,649,942.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,086,011,787.27	1,058,481,052.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	803,026,100.54	758,020,058.81
210101	Үндсэн цалин	522,558,902.54	500,262,242.50
210102	Нэмэгдэл	200,721,534.00	200,515,354.40
210104	Урамшуулал	69,666,506.00	47,462,431.45
210105	Гэрээт ажлын хөлс	10,079,158.00	9,780,030.46
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	100,254,217.00	102,681,751.69
210201	Тэтгэврийн даатгал	68,172,626.16	72,371,409.24
210202	Тэтгэмжийн даатгал	8,019,998.87	7,494,774.81
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,416,486.85	6,084,149.10
210204	Ажилгүйдлийн даатгал	1,604,326.66	1,527,154.40
210205	Эрүүл мэндийн даатгал	16,040,778.46	15,204,264.14
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	00.00	00.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	126,645,985.73	132,507,391.00
210301	Гэрэл, цахилгаан	7,793,684.00	4,671,471.20
210302	Түлш, халаалт	118,702,301.73	127,535,919.80
210303	Цэвэр, бохир ус	150,000.00	300,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,633,450.00	11,236,362.00
210401	Бичиг хэрэг	618,300.00	1,218,772.00
210402	Тээвэр, шатахуун	4,549,500.00	4,608,890.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	582,000.00	571,800.00
210404	Ном, хэвлэл	561,350.00	408,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,047,200.00	2,576,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,275,100.00	1,852,300.00
2105	Нормативт зардал	23,324,784.00	26,364,089.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	292,500.00	296,000.00
210502	Хоол, хүнс	21,670,784.00	25,198,089.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,361,500.00	870,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,574,450.00	17,694,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,922,000.00	15,280,000.00

Өндөрхангай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210602	Тавилга	7,161,650.00	00.00
210604	Урсгал засвар	2,490,800.00	2,414,500.00
2107	Томилолт, зочны зардал	310,000.00	750,000.00
210702	Дотоод албан томилолт	310,000.00	750,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,164,000.00	2,157,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	500,000.00	499,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	224,000.00	403,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	79,500.00	79,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	37,500.00	37,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	323,000.00	1,137,500.00
210807	Газрын төлбөр	00.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,078,800.00	7,069,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,078,800.00	7,069,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	57,480,262.73	48,168,889.50
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,833,200.00	25,549,620.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	15,438,700.00	24,095,120.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,394,500.00	1,454,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	1,483,000.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	1,483,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	115,514.27	10,233,009.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	115,514.27	10,233,009.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	40,531,548.46	10,903,230.50
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	40,531,548.46	10,903,260.50
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>4,869,150.00</u>	<u>00.00</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	00.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	4,869,150.00	00.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,869,150.00	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	4,869,150.00	00.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4,869,150.00	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-4,869,150.00</u>	<u>00.00</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4. АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	1,152,299,976.73	271,070,409.07	364,168,513.13	1,787,538,898.93
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,152,299,976.73	271,070,409.07	364,168,513.13	1,787,538,898.93
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	71,569,600	00.00	00.00	71,569,600
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-28,604,703.32	-28,604,703.32
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,223,869,576.73	271,070,409.07	335,563,809.81	1,830,503,795.61
D01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	1,223,869,576.73	271,070,409.07	335,563,809.81	1,830,503,795.61
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	156,843.00	156,843.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,223,869,576.73	271,070,409.07	335,720,652.81	1,830,660,638.61
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-156,843.00	00.00	-156,843.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-45,133,557.08	-45,133,557.08
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,223,869,576.73	270,913,566.07	290,587,095.73	1,785,370,238.53

2.5. АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

ЭЗА	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,096,389,500.00	1,075,253,130.50	21,136,369.5	98.1%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,096,389,500.00	1,075,253,130.50	21,136,369.5	98.1%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,070,936,900.00	1,049,803,510.50	21,133,389.5	98.0%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	762,451,100.00	758,020,058.81	4,431,041.2	99.4%
210101	Үндсэн цалин	502,039,800.00	500,262,242.50	1,777,557.5	99.6%
210102	Нэмэгдэл	200,722,800.00	200,515,354.40	207,445.6	99.9%
210104	Урамшуулал	49,608,500.00	47,462,431.45	2,146,068.6	95.7%
210105	Гэрээт ажлын хөлс	10,080,000.00	9,780,030.46	299,969.5	97.0%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	102,930,900.00	102,681,751.69	249,148.3	99.8%
210201	Тэтгэврийн даатгал	72,432,900.00	72,371,409.24	61,490.8	99.9%
210202	Тэтгэмжийн даатгал	7,624,500.00	7,494,774.81	129,725.2	98.3%
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,099,600.00	6,084,149.10	15,450.9	99.7%
210204	Ажилгүйдлийн даатгал	1,524,900.00	1,527,154.40	-2,254.4	100.1%
210205	Эрүүл мэндийн даатгал	15,249,000.00	15,204,264.14	44,735.9	99.7%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	142,654,900.00	132,507,391.00	10,147,509.0	92.9%
210301	Гэрэл, цахилгаан	9,850,000.00	4,671,471.20	5,178,528.8	47.4%
210302	Түлш, халаалт	132,504,900.00	127,535,919.80	4,968,980.2	96.2%
210303	Цэвэр, бохир ус	300,000.00	300,000.00	0.0	100.0%
2104	Хангамж, бараа материалын зардал	9,871,700.00	9,328,820.00	542,880.0	94.5%
210401	Бичиг хэрэг	620,800.00	529,230.00	91,570.0	85.2%
210402	Тээвэр, шатахуун	4,589,400.00	4,305,890.00	283,510.0	93.8%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	582,400.00	571,800.00	10,600.0	98.2%
210404	Ном, хэвлэл	562,000.00	408,600.00	153,400.0	72.7%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,176,000.00	2,176,000.00	0.0	100.0%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,341,100.00	1,337,300.00	3,800.0	99.7%
2105	Нормативт зардал	31,356,800.00	26,364,089.00	4,992,711.0	84.1%
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	296,800.00	296,000.00	800.0	99.7%
210502	Хоол, хүнс	29,935,500.00	25,198,089.00	4,737,411.0	84.2%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,124,500.00	870,000.00	254,500.0	77.4%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,500,000.00	15,414,500.00	85,500.0	99.4%
210601	Багаж, техник, хэрэгсэл	13,000,000.00	13,000,000.00	0.0	100.0%
210604	Урсгал засвар	2,500,000.00	2,414,500.00	85,500.0	96.6%

Өндөрхангай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2107	Томилолт, зочны зардал	1,128,800.00	750,000.00	378,800.0	66.4%
210702	Дотоод албан томилолт	1,128,800.00	750,000.00	378,800.0	66.4%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,677,100.00	1,457,200.00	219,900.0	86.9%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	500,000.00	499,500.00	500.0	99.9%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	403,200.00	403,200.00	0.0	100.0%
210803	Даатгалын үйлчилгээ	119,500.00	79,500.00	40,000.0	66.5%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	138,400.00	37,500.00	100,900.0	27.1%
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	33,000.00	00.00	33,000.0	0.0%
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	483,000.00	437,500.00	45,500.0	90.6%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3365600.00	3,279,700.00	85,900.0	97.4%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,365,600.00	3,279,700.00	85,900.0	97.4%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,452,600.00	25,449,620.00	2,980.0	100.0%
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,452,600.00	25,449,620.00	2,980.0	100.0%
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	24,098,100.00	24,095,120.00	2,980.0	100.0%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,354,500.00	1,354,500.00	0.0	100.0%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,096,389,400.00	1,096,389,400.00	0.0	100.0%
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	951,234,500.00	951,234,500.00	0.0	98.9%
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	145,154,900.00	145,154,900.00	0.0	93.0%
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00		
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	61.00	61.00		100.0%
620001	Удирдах ажилтан	01.00	01.00		100.0%
620002	Гүйцэтгэх ажилтан	41.00	41.00		100.0%
620003	Үйлчлэх ажилтан	18.00	18.00		100.0%
620004	Гэрээт ажилтан	01.00	01.00		100.0%

2.6. АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		8,777,542.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		8,777,542.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		8,677,542.00
2104	Хангамж, бараа материалын зардал		1,907,542.00
210401	Бичиг хэрэг		689,542.00
210402	Тээвэр, шатахуун		303,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		400,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		515,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		2,280,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		2,280,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		700,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		700,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		3790000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		3,790,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		100000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		100,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		100,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		10260542.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		10,260,542.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		10,260,542.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны Өндөрхангай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Амармэнд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Өндөрхангай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Өндөрхангай сумын Ерөнхий боловсролын сургууль нь энэ хичээлийн жилд Хүүхдийн хөгжлийг дэмжих, сурлагын хоцрогдлыг арилгахад бүх талын хамтын оролцоог ханган хичээл сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах зорилгын хүрээнд зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг төсвийн тухай хуульд өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд аймгийн Орон нутгийн өмчийн газраас орон нутгийн өмчийг эзэмшүүлэх гэрээний биелэлтийн талаар хяналт мониторинг, Мэргэжлийн хяналтын газраас Хөдөлмөрийн тухай хууль, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуулиуд тэдгээртэй нийцүүлэн гаргасан эрх зүйн актын хэрэгжилтийг шалгаж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд 9 зөвлөмж өгснийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба эрсдэлд суурилсан дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өндөрхангай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 0.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 4,881.1 мянган төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,191,687.3 мянган төгрөгөөс 0.5 хувиар буюу 5,958.4 мянган төгрөгийн 80 хувиар буюу 4,766.7 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлан гарах цагалбарт хугацаа болоогүй байсан тул материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар дахин шинэчлэн тогтоосон.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Өндөрхангай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 46,195.7 мянган төгрөгөөр буюу 2.5 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	14,092.9	25,609.9	11,517.0
Бараа материал	54,124.9	66,839.9	12,715.0
Үндсэн хөрөнгө	1,763,457.1	1,693,029.2	-70,427.8
Нийт хөрөнгө	1,831,675.0	1,785,479.2	-46,195.8
Өр төлбөр	1,171.2	109.0	-1,062.2
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,830,503.7	1,785,370.2	-45,133.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,831,675.0	1,785,479.2	-46,195.8

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн данс үлдэгдэлгүй байна.

Авлага дансны үлдэгдэл 25,609.9 мянган төгрөг болж 11,517.0 мянган төгрөг болж өссөн нь тайлант онд 13,000.0 төгрөгийн ухаалаг самбар худалдан авч мөнгө шилжүүлсэн боловч ковид цар тахлын улмаас хил гааль хаасантай холбоотойгоор тоног төхөөрөмжийг авлагаар бүртгэсэн, өмнөх оны авлагаас 1,483.0 мянган төгрөгийн авлага буурсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 66,839.9 мянган төгрөг болж 12,715.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд зарцуулаагүй бараа материалын үлдэгдлээс шалтгаалсан байна. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,693,029.2 мянган төгрөг болж 70,427.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны элэгдлийн зардал 99,305.6 мянга, ашиглалтын хугацаа дууссан үндсэн хөрөнгийг акталж данс бүртгэлээс хассан 134,390.0 мянга, балансаас баланст шилжүүлсэн 8,887.8 мянга, үнэ төлбөргүй хүлээн авсан 39,049.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,785,553.9 мянган төгрөг болж 45,133.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 38,656.6 мянган төгрөгөөр буюу 3.2 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан нь авлага, үндсэн хөрөнгө, бараа материал, өр төлбөрийн данс байна. Энэ нь авлага, бараа материалын данс өссөн, үндсэн хөрөнгө, өр төлбөр данс буурсантай холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 32,300.9 мянган төгрөгөөр буюу 2.6 хувиар буурсан нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, цалин, шимтгэлийн зардлууд байна.

Тайлант онд шинээр өр төлбөр үүсээгүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Өндөрхангай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,043,334.7 мянган төгрөгөөр, нийт зардлыг 1,043,334.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг хүргүүлсэн санал болох 1,043,334.7 мянган төгрөгөөр баталсныг төсвийн тодотгол хийгдэж 53,054.7 мянган төгрөгөөр өссөн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,096,389.5 мянган төгрөгийн төсөв баталснаас 951,234.5 мянган төгрөгийг улсын төсвөөс, 145,154.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын болон орон нутгийн төсвөөс 1,096,389.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 1,075,253.1 мянган төгрөгийг зарцуулж 21,136.2 мянган төгрөгийг улс, орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,075,253.1 мянган төгрөг буюу 98,1 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Өндөрхангай сумын Ерөнхий боловсролын сургуулийн нэмэлт санхүүжилтийн дансаар Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 10,260.5 мянган төгрөгийн орлого орсныг зарцуулалтын эрх нээлгэн зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт дансны орлогын гүйцэтгэлийг зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 706.1-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБООУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан ерөнхий чиглэлийн дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан шалгасан. Стандарт, хэмжил зүйн хэлтсийн хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 2020 оны санхүүгийн тайлангаар албан шаардлага өгсөн тул А/108 дугаар тушаалаар өгсөн ерөнхий чиглэлийн хавсралт 1 маягтаар нарийвчилсан горим хэрэгжүүлэхэд зөрчил илрээгүй болно.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 147, хугацаа хоцорсон 2, хугацаа болоогүй 2 мэдээлэл байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал байхгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой зөвлөмж өгснийг 2021 оны 03 дугаарын сарын 17-ны өдрийн албан бичгээр биелэлтийг тайлагнасан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 5,684.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснийг залрууллаа.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.6 дахь заалтад “Бүх зардал” гэж заасныг зөрчин 2019 оны санхүүгийн тайланд хоолны зарлагыг 5,684.8 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн алдааг Санхүү хяналт аудитын албаны тогтоосон акт, хоолны зардлын түүврийг үндэслэн 2021 оны санхүүгийн тайланд 5,684.8 мянган төгрөгийн хоол хүнсний зардлыг бүртгэж залрууллаа.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Өндөрхангай сумын Ерөнхий боловсролын сургууль	1	5,684.8	1	5,684.8						
	ДҮН	1	5,684.8	1	5,684.8						

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  /М.БАТЦУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР  /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР  /Т.АМАРМЭНД/

2022 оны 02 сарын 25-ний өдөр